



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Н.ТАВИНБЭХ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: somcog@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024.06.18 № 03/10633.
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газраас улсын хэмжээнд гадаадын зээл, тусламжийн хэрэгжиж буй томоохон төсөл, хөтөлбөрүүдэд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж байна.

Энэ хүрээнд эрчим хүчний салбарт хэрэгжиж буй төслийн нэгжүүдийн холбогдох албан тушаалтнуудтай 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр уулзалт зохион байгуулж, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, авлигын эрсдэлийг бууруулах чиглэлээр мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч, харилцан санал солилцлоо. Мөн төсвийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт, зураг төсөлгүй зохион байгуулсан худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, төсөл, хөтөлбөрүүд хугацаандаа хэрэгжихгүй, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн байна.

Иймд Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай Зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна.

Зөвлөмжид дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэн Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хариу ирүүлнэ үү.

Хавсралт 5 хуудастай.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З БААСАННЯМ

Авлигатай тэмцэх газрын
2024 оны 06 дугаар сарын 11-ны
өдрийн 05/1089 дугаар албан бичгийн
хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

УХА0422 5120820

Авлигатай тэмцэх газраас эрчим хүчний салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр болон улсын төсвийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, мэдээллийн ил тод байдалд дүн шинжилгээ хийж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж байна.

Зөвлөмж 1. Эрчим хүчний салбарын хэмжээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удаашралтай хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн шалтгаан, нөхцөлийг арилган төсөл, хөтөлбөрийн үр дүнг нэмэгдүүлэх, төсөл хэрэгжүүлэх нэгжүүдэд мэргэжлийн шаардлага хангасан мэргэжилтнийг нээлттэй сонгон шалгаруулалтаар томилох.

Нөхцөл байдал:

Эрчим хүчний салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа зарим төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт удаашралтай, хугацаандаа хэрэгжээгүй байна. Тухайлбал,

- Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импортын банкны санхүүжилтээр "Арван аймгийн төвийн дулааны станц барих төсөл" нь 2019-2024 онд хэрэгжиж байгаа бөгөөд төслийн хэрэгжилтийн явц 35 хувьтай, хугацаандаа хэрэгжихээргүй нөхцөл байдалтай, удаашралтай байна. Төсөл хэрэгжих хугацаа дуусч байхад төслийн 4 дэх багц болох "Архангай аймгийн төвд баригдах дулааны станцын төсөл"-ийг үргэлжлүүлэх, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил амжилтгүй болсон, төсөл хэрэгжиж буй 9 аймгийн хэмжээнд барилга угсралтын ажил төлөвлөсөн хугацаанаас 7-9 сарын хоцрогдолтой, зураг төсөлтэй холбоотой материал ханган нийлүүлэлт удааширсан, захиалга хийгдээгүй байгаа тоног төхөөрөмж олон байна. Мөн дулааны шугамыг дахин захиалах шаардлагатай, яндангийн ажлын зургийг хянаж дуусаагүй, төслийн талбай дээр гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч нарын удирдлага зохион байгуулалт хангалтгүй, барилга угсралтын ажилд шаардлагатай бараа материалыг хугацаанд нь татан аваагүй, тоног төхөөрөмж үйлдвэрлэгчийн техникийн мэдээлэл байхгүйн улмаас хойшлогдсон зэрэг нөхцөл байдалтай байна.

- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2023-2025 онд хэрэгжиж буй "Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төсөл"-ийн гүйцэтгэлийн үе шат эхлээгүй, төсөл хэрэгжих зарим сумдыг сонгох ажил үргэлжилж байгаа, төсөл хэрэгжих нэгжийн 2024 оны худалдан авалтын төлөвлөгөөнд заасан "Хамтран ажиллах иргэний нийгмийн байгууллага"-ыг сонгон шалгаруулах ажлын даалгаврыг боловсруулж байгаа боловч сонгон шалгаруулалтын процесс нь 6 сар үргэлжилдэг, иргэний нийгмийн байгууллагын хийх ажил нь төслийн үлдсэн хугацаанд амжихгүй байх эрсдэлтэй байна.

Эрчим хүчний салбарт хэрэгжиж буй төслийн нэгжийн зохицуулагч, ахлах инженер зэрэг албан тушаалтнуудтай зохион байгуулсан уулзалтаар зарим төслийн нэгжүүдэд хүний нөөц хүрэлцдэггүй, зарим тохиолдолд төслийн нэгжид мэргэжлийн бус хүмүүсийг томилон ажиллуулдагаас барилгын ажлын хэрэгжилтэд хяналт тавих боломж хязгаарлагдмал байдаг, төслийн хүрээнд гэрээ байгуулсан гүйцэтгэгч нар хугацаа сунгагдсанаар үнийн өсөлттэй холбогдуулан ажлаа гүйцэтгэх боломжгүй

болсон зэрэг асуудлууд хөндөгдсөн. Энэ нь төсөл хөтөлбөр үр дүнгүй хэрэгжих, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хугацаандаа хэрэгжихгүй байх, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлд хүргэж байна. Иймд Эрчим хүчний яамнаас салбарын хэмжээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд нэгдсэн дүн шинжилгээ хийх, удаашралтай байгаа төслүүдийг эрчимжүүлэх, цаашид төсөл, хөтөлбөрийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

Зөвлөмж 2. Эрчим хүчний салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, хөтөлбөрийн зардал, хэрэгжилт, явц, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлэх;

Эрх зүйн зохицуулалт:

№	Эрх зүйн актын нэр	Холбогдох зохицуулалтын агуулга
1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	8.4. Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана: 8.4.26. Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн
2	Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан "Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам"	7.1. Төсөл хэрэгжүүлэх нэгж төслийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах, үнэлэхэд дараах зарчмыг баримтална: 7.1.3. ил тод байдлыг хангах; 7.4.1. "гэрээ, хэлэлцээр, төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон худалдан авалтын төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилт, гүйцэтгэл, тайлагналтыг олон нийтэд тогтоосон хугацаанд мэдээлэх", 7.4.2. "төсөлд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ болон санхүүгийн тайланг олон нийтэд мэдээлэх", 24.9. Төсөл хэрэгжүүлэх нэгж төслийн хэрэгжилт болон санхүүжилтийн зарцуулалтын мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд дор дурдсаны дагуу оруулна: 24.9.1. ТХН-ийн санхүүгийн ажилтан төслийн санхүүжилт болон төслийн хүрээнд нийлүүлсэн бараа, материал, тоног төхөөрөмжийн гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр бүртгэх; 24.9.2. ТХН-ийн ХШҮ-ний ажилтан дор дурдсан мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд тухай бүр оруулах: 24.9.2.1. төсөл хэрэгжиж эхлэх үед: системд төслийн мэдээллийг үүсгэх, шалгуур үзүүлэлт, түүний зорилгод түвшний мэдээлэл болон төслийн үндсэн баримт бичгүүдийг файлын санд; 24.9.2.2. төслийн хэрэгжилтийн үед: төслийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл, ХШҮ-ний ажлын хэсгийн тайлан, төслийн хяналт-шинжилгээний тайлангуудыг тухайн санхүүгийн жилийн эцсийн байдлаар файлын санд; 24.9.2.3. төсөл дуусах үед: төслийн эцсийн тайлан болон төсөл дуусахтай холбоотой бүх мэдээ, төслийн үр нөлөөний үнэлгээний талаарх мэдээллийг файлын санд.

3	Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"	<p>13.3. Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага, төсөл хэрэгжүүлэх нэгж нь энэ журмын 13.2-т заасны дагуу гадаад зээлийн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлт, ашиглалт, бүртгэл, санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, хяналт, үнэлгээ, тайлагналыг тухай бүр цахим систем ашиглан гүйцэтгэн ил тод байдлыг хангах бөгөөд мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.</p> <p>13.11. Нууцын тухай хууль тогтоомж, зээлийн гэрээнд зааснаас бусад тохиолдолд гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, санхүүжилтийн мэдээлэл болон бүртгэл, тайлагналт ил тод байна;</p> <p>13.13. Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний жагсаалт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг www.iltod.mof.gov.mn, odamis.mof.gov.mn, publicinvestment.gov.mn болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагын цахим хуудаст тухай бүр мэдээлнэ.</p>
---	--	--

Нөхцөл байдал:

Эрчим хүчний салбарт 2024 оны байдлаар гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл хөтөлбөрийн мэдээллийн ил тод байдлыг хангаж байгаа эсэхэд Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн "Удирдлагын мэдээллийн систем" буюу odamis.mof.gov.mn цахим системд дүн шинжилгээ хийхэд тус салбарт хэрэгжиж буй 10 төсөл хөтөлбөрийн "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц" барих төслийн мэдээлэл огт ороогүй байв. Odamis.mof.gov.mn цахим системд системд орсон 9 төсөл, хөтөлбөрийн 4 нь мэдээллээ бүрэн оруулсан, Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төсөл, Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл, Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл, Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төсөл зэрэг 5 төсөл, хөтөлбөр нь мэдээллээ бүрэн бус оруулсан болон огт байршуулаагүй байна.



Зөвлөмж 3. Эрчим хүчний салбарын хэмжээнд төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, хуульд заасан үндэслэлээс бусад тохиолдолд зураг төсөл батлагдаагүй байхад худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байх, төсөл, арга хэмжээг хугацаанд нь бүрэн гүйцэд, үр дүнтэй хэрэгжүүлэх;

Эрх зүйн зохицуулалт:

Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2}-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх", 29^{1.2.2}-т "барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;" 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэж заасан.

Нөхцөл байдал:

Эрчим хүчний салбарт төсвийн хөрөнгөөр 2024 оноос өмнө хэрэгжиж эхэлсэн, 2024 онд хэрэгжиж дуусах зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт удаашралтай, хангалтгүй байна.

• "Ховд дулааны станц"-ын өргөтгөл төсөл арга хэмжээ нь 2022 оноос төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа бөгөөд гүйцэтгэгч "Майнтек технологи" ХХК-тай байгуулсан анхны гэрээнд 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр өргөтгөлийг ашиглалтад оруулахаар заасан боловч 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар барилга угсралтын ажлын гүйцэтгэл 49 хувьтай, өргөтгөлийн барилгын каркас угсралтын ажил, сэндвичин хавтангийн галын дүгнэлтийг онцгой байдлын ерөнхий газраар гаргуулсан, 23 МВт-ын хүчин чадалтай зуухны нүүрсний бункер суурилуулах ажил хийгдсэн байдалтай байна.

• Төв аймгийн Зуунмод сум дахь "Дулааны станцын халаалтын 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар хэсгийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл" төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлын явц 10 хувьтай, нийт 12.81 км шугам шинэчлэлтийн ажил хийгдэхээс 600 м орчим шугамын ажил хийгдсэн, барилга угсралтын ажил 8/15-ны өдрөөс үнийн өсөлт болон ажлын тоо хэмжээний зөрүү, тооцуулж магадлалаар оруулах гэсэн шалтгаанаар ажил зогссон байдалтай байна.

• Сум, суурин газрын цахилгаан хангамж, шугам сүлжээ, дэд станц /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний 1 дүгээр багц болох Баян-Өлгий аймгийн Баяннуур, Бугат гэсэн 2 байршилд баригдах цахилгаан хангамж, шугам сүлжээ, дэд станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 25 хувьтай, анх байгуулсан гэрээний хугацаа 2023.11.01-нд дууссан байна.

• Булганы аймгийн Тэшиг сумын төвийн 35 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамын төсөл, арга хэмжээний барилга, угсралтын ажлын явц 28 хувьтай байна.

• "Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц" төсөл, арга хэмжээний "Шинэ Зуунмод" хотын эхний ээлжийн ус хангамжийн шугам сүлжээний ажлын үргэлжлэл /Төв, Сэргэлэн/ төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлын явц 32 хувьтай байна.

Эрчим хүчний яамнаас 2021-2022 онуудад 4 зураг төсөлгүй худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас "Ховд дулааны станц"-ын өргөтгөл төсөл арга хэмжээ нь дээр дурдсанчлан хугацаандаа хэрэгжих магадлал багатай байна. Мөн 2022 онд хэрэгжиж эхэлсэн "Ховд аймагт Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах" төсөл арга хэмжээний анхны төсөв нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар 3.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 15.7 тэрбум (15,748,200,000) болсон байна. Улмаар тус төсөл арга хэмжээний "Үйлдвэрийн барилга байгууламж" ажилд шалгарсан "Смарт энтерпрайз" ХХК болон "Рутан" ХХК-ийн түншлэлтэй байгуулсан гэрээ 8.730 тэрбум төгрөг (анхны гэрээний үнийн дүнгээс 2.975 тэрбумаар илүү), "Тоног төхөөрөмж, дэд бүтэц"ийн ажилд шалгарсан "МЭЗ" ХХК-тай байгуулсан гэрээний дүн 7.018 тэрбум төгрөг (анхны гэрээний үнийн дүнгээс 1.396 тэрбумаар илүү) тус тус болжээ.

Цаашид зураг төсөлгүй худалдан авах ажиллагааг зохион байгуулж шалгаруулах нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хугацаандаа хэрэгжихгүй байх, төсөвт өртөг нэмэгдэж, хуулийн этгээдэд хууль бус давуу байдал олгох эрсдэлтэй болохыг анхаарна уу.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР